MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах мэргэжилтэн, манлайлагчдын клубын гуравдугаар чуулга уулзалт

А.Пүрэв, Клубын төвийн бүсийн зохицуулагч, УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газрын Ахлах шинжээч

(Улаанбаатар хот, 2021 оны 1-р сарын 21-ний өдөр)

Агуулга

- Клубын товч танилцуулга
- Клубын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Хэрэгжүүлсэн ажлууд
- Бэрхшээл сургамж

20 гаруй үйл ажиллагаа = 300 гаруй хүн /давхардсан тоогоор/



Клубын танилцуулга

- MERIT төсөл хамтрагч байгууллагуудын төлөөллийг хамруулан Жендэрийн клубыг 2018 оны 3-р сард байгуулсан.
- Энэхүү клуб нь мэдлэг мэдээллээ хуваалцах, асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн хувьд хөгжин дэвших боломжийг бүрдүүлэх талбар болохын зэрэгцээ сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн жендэрийн тэгш байдлыг хангах мэргэжилтэн, манлайлагчдын ажлын баг юм.
- Тус клубын гишүүдийн дунд онлайн болон биечилсэн уулзалтыг сар бүр зохион байгуулж, харилцан туршлага солилцохын зэрэгцээ жил бүр чуулдаг уламжлалтай.
- 2018 онд Дорнод аймагт, 2019 онд Дундговь аймагт тус тус чуулсан.

Клубын алсын хараа, зорилго

- **Алсын хараа**: Төрийн бүх шатанд жендэрийн мэдрэмжтэй байдлыг хэвшүүлэн, төлөвшүүлэхэд түүчээлнэ.
- **Зорилго:** Төрийн бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх зорилгоор гишүүд хоорондоо мэдлэг туршлагаа ахиулах, мэдээлэл солилцох, чадавхиа нэмэгдүүлэх, хамтран төсөл хэрэгжүүлэхэд оршино.
- **Гишүүнчлэл:** Төсөлтэй хамтран ажилладаг дараах байгууллагуудын төлөөллөөс бүрддэг.

  Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал, жуулчлалын яам, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Удирдлагын академи, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Шинжлэх ухааны академийн харьяа Газарзүй-геоэкологийн хүрээлэн, Дорнод аймаг, Дундговь аймаг, Сүхбаатар аймаг, Төв аймаг.

Өмнөх чуулга уулзалтууд



- Анхдугаар чуулга уулзалт, Дорнод аймаг, 2018 оны 12-р сарын 7-8-ны өдрүүд



- Хоёрдугаар чуулга уулзалт, Дундговь аймаг, 2019 оны 12-р сарын 12-13-ны өдрүүд

Гуравдугаар цахим чуулга уулзалт



Жендэрийн клуб/ MERIT



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах манлайлагч, мэргэжилтний клубын
2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Клубын алсын хараа: Төрийн бүх шатанд жендэрийн мэдрэмжтэй байдлыг хэвшүүлэн, төлөвшүүлэхэд түүчээлнэ.

Зорилго: Төрийн байгууллагын жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдөж, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад хувь нэмэр оруулна.

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжих хугацаа	2020 оны биелэлт	Хувиар	Хэрэгжилтийг хариуцах хүн
Зорилт 1. Жендэрийн клубын гишүүдийн ур чадвар сайжирч, клубын үйл ажиллагаа тогтворжсон байна.		Сургагч багш нарын хүргэсэн хичээл, тоо	0	2	Жилдээ	**0**	**0**	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
		Илтгэх ур чадвар сайжирсан гишүүдийн тоо, хүйсээр	0	5	Жилдээ	**11**	**100%**	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
		Хамтарч хэрэгжүүлсэн үйл ажиллагааы төрөл, тоо	0	3	Жилдээ	**3 (Дорнод, Дундговь, 14-р сургууль)**	**100%**	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
1.	Жендэрийн сургагч багш бэлтгэх (Анхан болон дунд шатны сургалт)	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	5	10	3-4-р улирал	**2**	**20%**	ЖҮХ, MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
2.	Дэйл Карнеги төвийн “Хүчирхэг илтгэл” сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	14	28	1, 2-р улирал	**15 (8 эрэгтэй, 7 эмэгтэй)**	**100%**	MERIT, Дэйл Карнеги Трэйнинг, Клубын 2020 оны зохицуулагчид
3.	Сайн туршлага судлах, сургалтад хамрагдах - Ижил төстэй гадны клубуудтэй холбогдох - Бусад төсөл, олон улсын байгууллагуудтай холбогдох, танилцах, туршлагаа хуваалцах	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	2	3	1-4-р улирал	**1 (APOLITICAL-ийн вебинар)**	**100%**	MERIT, ГГХ, Клубын 2020 оны зохицуулагчид
4.	Багийн ажиллагааг бэхжүүлэх дасгал ажил /зумба/	Сургалтад хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	0	10	1-4-р улирал	**0**	**0**	4 аймгийн ЗДТГ, MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид

Зорилт 2: Жендэрийн тэгш байдлын талаарх төрийн албан хаагчид болон олон нийтийн ойлголт сайжирсан байна.		Жендэрийн талаарх мэдлэг сайжирсан хүний тоо, хүйсээр	0	100	Жилдээ	**100**	**100%**	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
1.	"Жендэрийн дүн шинжилгээ" сургалт явуулах	Сургалтын тоо	1	6	3-4-р улирал	**1 (Ахисан түвшний ЖДШ цахим сургалт)**	**100%**	Төрийн захиргааны төв байгууллагын түвшинд
		Сургалтад хамрагдсан хүний тоо, хүйсээр	38	88		**12 (6 эмэгтэй, 6 эрэгтэй)**	**100%**	
2.	Хүүхэд, залуучуудад мэдлэг олгоход чиглэсэн ярилцлага, сургалт зохион байгуулах /Сэдэв: жендэр, хүний эрх, мэргэжил сонголт/ (УБ хотын 14-р сургууль, 4 аймаг бүр 1 сургууль)	Багш, сурагчдын тоо, хүйсээр	1 сургуулийн 180 гаруй хүүхэд	6 сургуулийн 680 хүүхэд	2, 4-р улирал	**1 (70 хүүхэд)**	**100%**	Төрийн захиргааны төв байгууллагын түвшинд
3.	Олон улсын Жендэрийн талаарх сайн туршлагыг түгээх (Канадын ЭСЯ-ны "Жендэрийн чиглэлээр ажилладаг донорын санхүүжилттэй төслүүд хоорондын ажлын уялдааг хангах" уулзалтуудад оролцох)	Семинарт хамрагдсан гишүүдийн тоо, хүйсээр	1 арга хэмжээ Оролцогчдын тоо 32	2 арга хэмжээ Оролцогчдын тоо 62-72	2-4-р улирал	**3 (Азийн сан, Олон улсын хөдөлмөрийн эрхзүйн байгууллага, Транспэрэнси Интернэшнлийн 3 төсөлтэй танилцсан)**	**100%**	MERIT-ийн 1 зөвлөх, Клубын 2020 оны зохицуулагчид
4.	Төрийн албан хаагчдад "Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх" сургалтыг клубын гишүүдээр дамжуулан зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байгууллагын тоо	0	2	2-4-р улирал	**1**	**100%**	Төрийн захиргааны төв байгууллагын түвшинд
		Сургалтанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, хүйсээр	0	120		**32**	**100%**	
Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн баримт бичиг батлагдсан байна.		Боловсруулж, батлуулсан бодлого, хөтөлбөрийн тоо	0	2	Жилдээ	**2 (Орон нутаг)**	**100%**	MERIT, Клубын 2020 оны зохицуулагчид
2.	Менторшип (зөвлөн туслах үйл ажиллагаа) өгөх	Зөвлөн туслах үйл ажиллагаа үзүүлсэн хүний тоо, хүйсээр	0	10	1-4-р улирал	**0 (Бүртгэл хийгээгүй)**	**0**	Бүх гишүүд

Хэрэгжүүлсэн ажлууд /5-р сар/

- Дэйл Карнеги Трэйнингтэй хамтран 2020 оны 5-р сарын 18,19-ний өдрүүдэд **"Хүчирхэг илтгэл"** сэдэвт хоёр өдрийн сургалтыг төрийн захиргааны төв байгууллагуудын төлөөллүүдийг /8 эрэгтэй, 7 эмэгтэй/ хамруулан хийсэн.
- Сургалтад ЗГХЭГ, УУХҮЯ, Үндэсний хөгжлийн газар, Жендэрийн үндэсний хороо, Ашигт малтмал, газрын тосны газар, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах газар, Газарзүй, гео-экологийн хүрээлэн, Төв аймгийн төлөөлөл оролцсон.
- 2020 оны 11-р сард орон нутгийн түвшний төлөөллүүдийг хамруулан явуулахаар төлөвлөсөн боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан.






Хэрэгжүүлсэн ажлууд /6-р сар/

- **"Жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх"** сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдөр АМГТГ-ын 2-р байран дээр зохион байгуулсан.

- Энэ үеэр Олон улсын хөгжлийн эрхзүйн байгууллага /IDLO/-аас хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн үйл ажиллагааны талаар танилцуулга сонсож, туршлага солилцохын зэрэгцээ хүрэлцэн ирсэн гишүүд /17 хүн хамрагдсанаас 6 эмэгтэй, 6 эрэгтэй сертификат авсан/ “Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ” цахим сургалтад хамрагдсан.

- Мөн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Х.Мөнхзул хүрэлцэн ирж, жендэрийн эрх тэгш байдал ба хүний эрх сэдвээр мэдээлэл хийсэн.







Хэрэгжүүлсэн ажлууд /6-р сар/

- Мөвийн бүсийн Зохицуулагч НҮБ-ын Хүүхдийн сан болон АПОЛИТИКАЛ-аас хамтран зохион байгуулсан “**Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах нь КОВИД-19-ын үр дагаврыг даван туулахад хэрхэн туслах**” талаарх Олон улсын семинарт 2020 оны 6-р сарын 24-ний өдөр цахимаар оролцож, клубын үйл ажиллагаа болон цар тахлын үеэрх уян хатан ажиллах зохицуулалтын сайн туршлагыг хуваалцав.

- Уг цахим арга хэмжээнд дэлхийн өнцөг булан бүрээс олон орны төрийн албан хаагчид болон НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөл бүхий 100 гаруй хүмүүс оролцлоо.





Хэрэгжүүлсэн ажлууд /9-р сар/

- Төлөвлөгөөний дагуу 2020 оны 9-р сарын 29-ний өдөр Нийслэлийн 14-р сургуулийн ахлах ангийн 70 гаруй сурагчдын дунд “**Ажил мэргэжил сонголт: Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик**” сэдвээр чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулав.

- Энэхүү арга хэмжээнд “Гайхамшигт 50: Жишиг өөрчилсөн түүх” номын 2 дүр, уг номын төслийг санаачлагч “Эрдэс баялаг эмэгтэйчүүд” ТББ-ын удирдлага оролцож өөрсдийн ШУТИМ салбар дахь карьер сонголт, ажил-амьдралын замналын түүхээ хуваалцахын зэрэгцээ, сурагчдын сонирхсон асуултад хариулж, яриа өрнүүллээ.







Хэрэгжүүлсэн ажлууд /10-р сар/

- Клубын 10-р сарын уулзалт 2020 оны 10-р сарын 28-ны өдөр боллоо.
- Энэхүү уулзалтаар Төвийн бүсийн зохицуулагч А.Пүрэв, орон нутгийн зохицуулагч А.Нарантуяа нар клубын хүрээнд төрийн захиргааны төв байгууллагууд болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн ажлуудаа танилцууллаа.
- Мөн Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй Азийн сангаас хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөр болон Австралийн ЗГ-ын санхүүжилттэй Транспэрэнси Интернэшнл Монголиа байгууллагын хэрэгжүүлж буй “Тогтвортой уул уурхайн хөгжил” төслийн төлөөллүүд танилцуулга хийв.





Сайхан мэдээ

- Олон улсын 100 гаруй орны төрийн албаны сайн туршлага солилцох платформ болох Apolitical-оос жендэрийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны сайн туршлагын нэгээр сонгогдож, Global Public Service Awards –н “Championing Equality – Эрх тэгш байдлыг манлайлагч” номинацид нэр дэвшсэн хариугаа хүлээж байна.



Сайхан мэдээ

- Өрсөлдөж буй улсууд:

- Коннект Онтарио – мэргэжилтнүүдийн сүлжээ, Канад
- Дижитал, соёл, хэвлэл мэдээлэл, спортын яамны Соёлын дипломат харилцааны баг, Их Британи
- Коста Меса хотын тогтвортой эрчим хүчний баг, АНУ
- “Ухаалаг тосгон төсөл”, Орон нутгийн хөгжлийн яам, Малайз
- “CHANGE – Хот ба жендэрийн эрх тэгш байдлын сүлжээ” олон улсын 6 хотын сүлжээ

Ontario

Department for Digital, Culture Media & Sport

BERSEKUTU BERTAMBAH MUTU

COSTA MESA CITY OF THE ARTS™ CALIFORNIA

CHANGE CITY HUB AND NETWORK FOR GENDER EQUITY

Сургамж

- Олон улсад Монгол Улс болоод өөрийн клубын туршлагыг таниулахад чиглэсэн ажлуудыг хийх нь зүйтэй. Одоогоор олон улсад гарах, танигдах суурь тавигдсан гэж үзэж байна.
- Дараагийн жилүүдэд үр дүнтэй нь батлагдсан зарим ажлуудыг /Дэйл Карнеги сургалт, олон улсын арга хэмжээ, өглөөний цай/ хэрэгжүүлдэг жишиг тогтоож болох юм.
- Орон нутгийн дэд клубыг байгуулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх, орон нутгийн гишүүдийн оролцоог бусад хэлбэрээр сайжруулах арга замуудыг эрэлхийлэх нь зүйтэй. Тухайлбал, Дорнод аймгийн дэд клуб маань ТББ болж, зохион байгуулагдсан нь сайн туршлага болохоор байна. Цаашлаад, бүх гишүүд өөрт дэмжлэг болох хүмүүсийг хамруулан, байгууллага дээрээ дэд клубыг байгуулж ажиллавал илүү их үр дүнд хүрэхээр байна.
- Зарим хэрэгжиж амжаагүй ажлууд үлдсэн байгаа. Магадгүй ирэх жилд тэдгээрийг авч хэрэгжүүлж болох юм.

Бэрхшээл

- КОВИД-19-ийн хязгаарлалт
- УИХ болон орон нутгийн сонгууль
- Гишүүд ажил, албан тушаа солих
- Гишүүдийн мэдлэг ойлголтын зөрүүтэй байдал
- Гишүүдийн ажлын ачаалал
- Гишүүдийг байгууллага дээр нь удирдлага, хамтран ажиллагсад нь дэмждэггүй байдал
- Хүмүүсийн харилцаа хандлага /эмэгтэй хүний тухай гэж ойлгох, бүх зүйлд жендэрийн асуудлыг тусгах нь өрөөсгөл гэж үзэх/
- Жендэр зөвхөн нэг хүний, нэг хорооны ажил гэж ойлгодог байдал
- Жендэр төрийн байгууллагын өдөр тутмын ажлаас тусдаа гэж ойлгох байдал, бодлогын циклд нэвтрэхгүй байх
- Жендэрийн холбогдолтой үйл ажиллагааны санхүүжилт дутмаг байдал

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Mongolia: Enhancing Resource Management through Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000